

БНХАУ-ЫН ШАШНЫ ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ БОДЛОГО

Ж.Лхагвадэмчиг
МУИС, Шинжлэх ухааны сургууль,
Антропологи-археологийн тэнхим,
доктор (PhD)

Товч агуулга: БНХАУ нь 2007 оноос хойш соёлын зөөлөн хүчний бодлогыг (*wenhua guan shili*) хэрш орнууд, дэлхий дахинд хүчтэй явуулж буй бөгөөд энэхүү бодлого нь БНХАУ-ын зүгээс гадаад улс орнуудад өөрийн эдийн засаг, улс төрийн нөлөөллөө тогтоох, аюулгүй байдал, эрх ашгаа хамгаалах стратегийн бодлоготой нь хамт хэрэгжиж буй бодлого юм. Энэхүү соёлын зөөлөн хүчний бодлогын хүрээнд БНХАУ нь шашны зөөлөн хүчний бодлогыг идэвхтэй явуулж байна. Энэхүү өгүүлэлд БНХАУ-ын зүгээс явуулж буй шашны зөөлөн хүчний бодлого түүн дотроо Буддын шашнаар дамжуулан явуулж буй бодлого, үйл ажиллагааны талаар ярина.

Түлхүүр үг: БНХАУ, Буддын шашин, зөөлөн хүчний бодлого, үйл ажиллагаа

Шашны нөлөө, оролцоо

Өгүүллийн эхэнд орчин үед улс төр, олон улсын харилцаанд шашны нөлөө, оролцоо¹ хэр байгаа талаар хоёр жишээн дээр тулгуурлан товчхон яриад үндсэн сэдэвтээ оръё.

Улс төрд шашны нөлөө хэвээр байгаагийн нэгэн жишээг саяхан болж өнгөрсөн АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын үр дүнгээс харж болох юм. Тухайлбал цагаан арьстан евангелист христийн шашинтуудын 76% нь Бүгд найрамдах намаас нэр дэвшигч Доналд Трамп-д саналаа өгсөн.² Харин уг санал нь 2016 онд 81%-тай байжээ.³

1 Улс төр, олон улсын харилцаан дахь шашны оролцоо, нөлөөллийн тухай судалгаа 1990-д оноос хойш эрчимжиж эхэлсэн (Casanova 1994; Fox and Shmuel Sandler 2004; Haynes 2009, 2016; Moysen 1991; Norris and Ronald Inglehart 2004; Thomas 2005). Орчин үежих тусам нийгэм дэх шашны нөлөө улам бууран, шашин нь нийтийн орон зайнаас (*public space*) хувь хүний орон зай (*private space*) руу шилжин орно гэсэн онолын хандлагыг дахин харах болсон.

2 https://www.nytimes.com/interactive/2020/11/03/us/elections/exit-pollspresident.html?action=click&pgtype=Article&state=default&module=styl-n-elections-2020®ion=TOP_BANNER&context=election_recirc

3 АНУ-ын сонгууль дахь шашны нөлөөллийн талаар Green 2007-г харна уу.

Өнгөцхөн харахад шашны асуудал мэт боловч XIV Далай ламын хойд дүрийн асуудал олон улсын анхаарлын төвд байна. 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр АНУ-ын Конгресс “Tibet Policy and Support Act” (TPSA)¹-г баталсан бөгөөд улмаар АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трамп 12 дугаар сарын 27-ний өдөр гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр хууль болсон.² Уг TPSA нь 8 бүлэгтэй бөгөөд “Далай ламын залгамжлагч эсвэл хойд дүрийн талаарх бодлогын мэдэгдэл” (Statement of Policy Regarding the Succession or Reincarnation of the Dalai Lama) хэмээх III бүлэгт тусгайлан XIV Далай ламын хойд дүрийн талаар тусган заажээ.

Тус бүлэгт XIV Далай ламын хойд дүрийг тодруулахад одоогийн Далай ламын хүсэл, бичмэл захиасыг баримтлах бөгөөд хэрэв XV Далай ламыг тодруулахад БНХАУ-ын засгийн газар хөндлөнгөөс оролцох юм бол Төвөдийн буддын шашныг шүтэн дагагсад³ болон Төвөдийн ард түмний шашин шүтэх язгуур эрх чөлөөг зөрчсөнд үзэж XV Далай ламыг тодруулахад оролцсон БНХАУ-ын албан тушаалтны хөрөнгийг царцаах, АНУ-д нэвтрэн орох виз олгохгүй байх зэрэг санкц үзүүлэх талаар заажээ.

Уг TPSA батлагдсаны удаах өдөр нь БНХАУ-ын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Ван Вэнбин АНУ нь БНХАУ-ын дотоод асуудалд хөндлөнгөөс оролцож буйд эсэргүүцлээ илэрхийлсэн⁴ бөгөөд мөн хэвлэлийн төлөөлөгч Жао Лижянь хутагт хувилгаадыг БНХАУ-ын Төвөдийн хутагт хувилгаадын талаарх дүрэм журмын (*Zangchuan fojiao huofu zhuanli guanli banfa*)⁵ дагуу тодруулах бөгөөд үүнд Далай ламын дараах дүр ч хамаарна гэж мэдэгдсэн.⁶

Дээр дурдсан хоёр жишээ мөн 1979 онд өрнөсөн Ираны хувьсгал, АНУ-ын Christian right хөдөлгөөн, БНХАУ, БНЭУ-ын явуулж буй шашны дипломат бодлого, БНТУ-ын Дияанет (Шашны хэрэг эрхлэх ерөнхий газар),⁷ ХБНГУ-ын ГХЯ-ны дэргэдэх Шашин ба гадаад бодлогын хэлтсийн үйл ажиллагаанаас харахад дэлхийн улс орнууд улсын дотоод улс төр болон олон улсын харилцаанд шашны нөлөө, оролцоо байгааг ихээхэн анхааран үзэж шашны талаар тодорхой бодлого боловсруулан хэрэгжүүлж буйг харж болно.

БНХАУ-ын зөөлөн хүчний бодлого

Зөөлөн хүч хэмээх нэр томъёог Жозеф Най (1990) томъёолон гаргасан бөгөөд зөөлөн хүч гэдэг нь цэрэг арми, эдийн засгийн хүчээр албадан хүчилж айлган

1 <https://www.congress.gov/116/bills/hr4331/BILLS-116hr4331rfs.pdf>;

<https://www.congress.gov/bill/116th-congress/house-bill/4331/text>

2 <https://tibet.net/us-president-trump-signs-tibetan-policy-and-support-bill-cta-recognized-and-funding-for-tibet-provided/>

3 Энэтхэг, Монгол, ОХУ, Непал, Бутан, БНХАУ болон АНУ дахь Төвөдийн буддын шашин шүтэгсэдийг үүнд оруулан заасан байна.

4 https://www.fmprc.gov.cn/mfa_eng/xwfw_665399/s2510_665401/t1841988.shtml

5 http://www.gov.cn/ziliao/ffg/2007-08/02/content_704414.htm

6 https://www.fmprc.gov.cn/mfa_eng/xwfw_665399/s2510_665401/t1843027.shtml

7 Дияанетийн талаар Korkut 2010; Lord 2018-г үзнэ үү.

сүрдүүлэх, дарамт хөшүүрэг үзүүлэн “өөрийн хүссэнийг авах бус харин бусдын сэтгэлийг татах чадварыг” (Nye 2005: x) хэлнэ гэж томъёолсон байна.

БНХАУ-ын цэрэг, эдийн засгийн хүч чадал өсөн Ази, Номхон далайн бүс нутгийн хүчирхэг улс болох тусам хөрш орнуудын хувьд эдийн засгийн таатай байдлыг үүсгэж буй боловч газар нутгийн маргаантай байдал, хилийн мөргөлдөөн гарах болсон нь БНХАУ хүчирхэгжихээс болгоомжлох, үл итгэх, сэргийлэх улмаар хязгаарлан тогтоон барих эвсэлд нэгдэх нөхцөл байдлыг үүсгэж байна. Энэхүү олон улсын нөхцөл байдлыг намжаах, хатуу хүчээ зөөллөн олон улсын тавцанд өөрийн улсын дүр төрхийг сайжруулахын тулд БНХАУ нь зайлшгүй зөөлөн хүчний бодлого явуулж буй нь илт билээ. Монгол Улсын хувьд БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 онд Монгол Улсад албан ёсны айлчлал хийн хоёр тал 24 албан бичигт гарын үсэг зурснаас¹ хойш Хятадын зөөлөн хүчний бодлого Монгол Улсад мэдэгдэхүйц байдлаар өссөн.

Хэдийгээр Жозеф Найгийн томъёолсон зөөлөн хүчний талаар Хятадын эрдэмтэд 1993 оноос хойш судлан нэжгээд өгүүлэл хэвлүүлсэн боловч чухамдаа 2007 онд хуралдсан ХКН-ын XVII их хурлын баримт бичигт зөөлөн хүчний нэр томъёо албан ёсоор орсноор зөөлөн хүчний бодлого нь БНХАУ-ын албан ёсны бодлого болон хэрэгжих эхэллээ тавьсан (Zhan 2017: 23-24) бөгөөд эдүгээ БНХАУ-ын дарга Ши Жиньпингийн үед улам эрчимжин хэрэгжиж байна. БНХАУ-ын зөөлөн хүчний бодлогыг² тус улсын дарга Ши Жиньпингийн хэлсэн үгнээс тодорхой харж болно. Тэрээр

“Улсын соёлын зөөлөн хүчийг нэмэгдүүлэх нь “Хоёр 100 жил”-ийн зорилт болон Хятадын олон үндэстний сэргэн мандлын Хятадын мөрөөдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой...Улсын соёлын зөөлөн хүчийг нэмэгдүүлэхэд өнөө үеийн Хятадын үнэт зүйлийн үзлийг (Хятадын онцлогтой социализмын үнэт зүйл) дэлгэрүүлэхээр чармайх ёстой... бичиг соёлоор, эрдэм ухаанаар бусдыг бишрүүлж...Хятадын соёлын татах хүчийг харуулах ёстой...Улсын соёлын зөөлөн хүчний түвшинг дээшлүүлэхэд олон улсын тавцан дээр Хятадын дуу хоолойг хүчтэй болгох явдал чухал юм.” (Жиньпин 2019:208-210)

“...хөрш орнуудыг бидэнд илүү найрсаг, илүү ойр дотно ханддаг, илүү талархаж, илүү дэмждэг болгож, өөртөө татах хүчийг, эвийн хүчийг, нөлөөлөх хүчийг нэмэгдүүлэх ёстой.” (Жиньпин 2019:382)

БНХАУ-ын зөөлөн хүчний бодлого нь дэлхийд Хятадын хөгжлийн загвар буюу Хятадын онцлогтой социализмын загварыг “олон улсын солилцоонд оруулж,

1 Ганбат, Би Аонань 2014: 535-538. Баримт бичгийн дагуу ирэх таван жилийн туршид (2014-2019) Хятадын талаас Монголын талд 1,000 сургалтын квот олгох, тэтгэлгийн 1,000 квот шинээр олгох, Монголын 500 цэргийн албан хаагчийг сургах, 500 залуус, 250 сэтгүүлчийг Хятадад айлчуулах, Хятадын шилдэг 25 кино, телевизийн нэвтрүүлгийг үнэ төлбөргүй өгөх, Монголын тал МУИС-ийн Күнзийн институт, Улаанбаатар дахь Хятадын соёлын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр тохиролцсон байна (Ганбат, Би Аонань 2014: 555, 558).

2 Хятадын зөөлөн хүч гэж юуг хэлэх вэ гэдэг талаар Хятадын эрдэмтдийн байр суурийг Shambaugh 2013:167-172-д үзнэ үү.

тал бүрээр түгээн дэлгэрүүлэх” (Жиньпин 2019: 209), Хятадын дуу хоолойг олон улсын тавцанд хүчтэй болгох, Монгол Улс тэргүүтэй хөрш орнууд болон бусад улс орнуудыг өөртөө татах, нөлөөлөх хүчийг нэмэгдүүлэхэд оршиж байна.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд Хятадын хэл соёлыг түгээх Күнзийн институтийг олноор байгуулах, гадаад оюутны тэтгэлгийн тоог нэмэх, НҮБ-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оройлон оролцох, олон улсын томоохон хурал уулзалтыг зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байгаа¹ бөгөөд эдгээр үйл ажиллагааны нэг нь шашнаар дамжуулан өөртөө татах, нөлөөлөх бодлого, үйл ажиллагаа юм.

БНХАУ-ын шашны зөөлөн хүчний бодлого

БНХАУ-ын Улсын шашны хэрэг эрхлэх газрын дарга Е Шяовень (1995-2007/9 хүртэл) 1997 онд ХКН-ын Намын төв сургуульд “Бид шашны нөлөөллийг аажмаар багасгана” (Xiaowen 2000) хэмээн хэлж байсан бол 2006 онд Хятадын Ханжоу хотноо зохион байгуулагдсан Дэлхийн Буддын шашны Форум (*Shijie Fojiao Luntan World Buddhist Forum*) дээр тэрээр Буддын шашин нь “Хятадын эртний шашин”, Хятад орон бол “Буддын шашинт аугаа улс” (Angelskar 2013) хэмээн цохон тэмдэглэжээ.

Түүний хэлсэн үг нь зөрчилтэй мэт харагдах боловч шашны талаар ХКН-ын баримталж буй бодлогын тод илрэл гэж хэлж болно. ХКН-ын шашны талаар баримталж буй дотоод бодлого нь улс орны дотор шашны нөлөөг бууруулах, нэн ялангуяа гаднын шашны нөлөөг хязгаарлах, таслан зогсоох, сүм хийдийг “эдийн засгийн эргэлтэд” оруулах, марксизм, ленинизм, Мао Зэдуны үзэл санааг удирдлага болгосон Хятадын онцлогтой социалист нийгэм байгуулах замд шашныг удирдан залах² бодлого юм. Харин шашны гадаад бодлого нь шашнаар дамжуулан олон улсын тавцанд Хятадын дуу хоолойг хүчтэй болгох, өөртөө татах, нөлөөллөө тогтоох, ашиг сонирхлоо хүчтэй илэрхийлэх, хэрэгжүүлэх зорилгыг агуулж байна.

Энэхүү шашны гадаад бодлого буюу шашны дипломат бодлогын хүрээнд БНХАУ нь Буддын шашны дипломат бодлого, үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Уг бодлого, үйл ажиллагаа нь бусдын сэтгэлийг өөрт татах, улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөх зөөлөн хүчний бодлогоос гадна цэрэг арми, эдийн засаг, улс төрийн нөлөөллөө тогтоох, аюулгүй байдал, эрх ашгаа хамгаалах стратегийн бодлоготой нь хамт хэрэгжиж байгаа билээ. Өөрөөр хэлбэл БНХАУ-ын зүгээс хэрэгжүүлж буй буддын төсөл хөтөлбөр нь нэг талаас харахад Буддын

1 Хятадын зөөлөн хүчний бодлого, үйл ажиллагааны талаар Breslin 2020: 137-155; Lai and Yiyi Lu 2012; Li 2009; Klimes 2017; Kurlantzick 2007; Modi 2016: 127-143; Palit 2017; Peterson 2017; Wang 2011; Zhang, Herman Wasserman, and Winston Mano 2016-д үзнэ үү.

2 Шашныг удирдан залах талаар “Эх орноо хайрлах, шашнаа хайрлахад (*aiguo aijiao*) шашныг идэвхтэй удирдахаас гадна социалист нийгэмд шашин өөрөө зохицон өөрчлөгдөх хэрэгтэй” хэмээн үзэж байна. (Litian 2014:345). Дэлгэрүүлэн Litian 2014: 336-347-д харна уу.

шашныг дэмжиж буй төсөл мэт боловч нөгөө талдаа тус улсын цэрэг, эдийн засаг, улс төрийн стратеги зорилт, зорилгодоо хүрэхэд нь туслах зам гүүр болж байна.

Уг бодлого, үйл ажиллагаа нь дараах үндсэн чиглэлүүдээр явагдаж байна. Үүнд а) Буддын шашныг дэмжигч, энхийг эрхэмлэгч улс орны дүр төрхийг бүрдүүлэх, Хятадын дуу хоолойг дэлхийн тавцанд хүргэх, холбоотон нетворк тогтоох зорилгоор олон улсын Буддын шашны том хэмжээний хурал зохион байгуулах, б) Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засаг, цэрэг, улс төрийн нөлөөллөө тогтоох бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй “Бүс ба зам” санаачилгын хүрээнд буддын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, в) Төвөдийн өндөрлөг бүсийн аюулгүй байдлаа хангах хүрээнд XIV Далай ламын нэр хүнд, нөлөөллийг бууруулан Бээжингээс тодруулсан XI Банчэн богдын нэр, нөлөөллийг нэмэгдүүлэх, Төвөдийн Буддын шашны урсгал хоорондын зөрчилдөөнийг ашиглах, Буддын шашны тэргүүд хутагт хувилгаад, сүм хийдийн хамба лам нарыг дэмжин өөрийн талд оруулах, XV Далай ламыг БНХАУ-аас тодруулах үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр үндсэн чиглэлүүдээс эхний хоёр чиглэлийн талаар ярья.

Буддын шашныг дэмжигч тэргүүлэгч улс орны дүр төрхийг бүрдүүлэх

Хэдийгээр Буддын шашин нь Даоизм адил Хятадад анхлан үүссэн Хятадын уугуул шашин биш боловч нэгд, буддын шашинтны тоогоороо Хятад улс нь дэлхийд тэргүүлж¹ байгаа, хоёрт, Буддын шашин нь III зууны үеэс Хятадад дэлгэрсэн² гэж үздэг, гуравт Хятадаас Буддын шашин Солонгос, Японд дэлгэрсэн, дөрөвт Хятад улсад Хан Буддизм (Хятадын Буддизм *Hanchuan Fojiao*), Төвөдийн Буддизм (*Zangchuan Fojiao*),³ Тхеравада (Буддын шашны бага хөлгөн урсгал) гурвуул байх тул Е Шяовений хэлснээр Буддын шашин нь “Хятадын эртний шашин”, Хятад орон бол “Буддын шашинт улс” гэж Азийн буддист орнуудад хэлэх үндэслэл бий. БНХАУ-ын дарга Ши Жиньпин НҮБ-ын ЮНЕСКО-гийн төв байранд хэлсэн үгэндээ “Хятад хүн хятадын соёлын дагуу Буддын сэтгэлгээг хөгжүүлж, Буддын шашны өвөрмөц онолыг (Хятадын онцлогтой буддын шашин *Zhongguo tese de Fojiao*) бүрдүүлсэн төдийгүй, Буддын шашин Хятадаас Япон, Өмнөд Солонгос, Зүүн өмнөд Ази зэрэг газар дэлгэрсэн билээ.” хэмээн цохон тэмдэглэжээ (Жиньпин 2019: 337).

1 2010 онд Хятадын буддын шашинтны тоо нь 244,110,000 бөгөөд дэлхийн нийт буддистуудын 50%-г эзэлж байсан бол 2050 он гэхэд 241,580,000 буюу 49.7%-г эзлэх төлөвтэй байна. <https://www.pewforum.org/2015/04/02/buddhists/> Хятадад 2020 оны байдлаар 254,700,000 буддист, 72,410,000 христийн шашин шүтлэгтэн, 28,010,000 исламын шашинтан байна. http://www.globalreligiousfutures.org/countries/china#/?affiliations_religion_id=0&affiliations_year=2010®ion_name=All%20Countries&restrictions_year=2016

2 Хятадын Буддын шашны түүхийг Ch'en 1964; Гомбожав 2016 [1746]; Haicheng 2005; Zürcher 2007 [1959]-д үзнэ үү.

3 Эдүгээ Хятадад Төвөдийн Буддизмыг *Lama jiao* (Ламын шашин) хэмээн нэрлэхээс илүүтэй Төвөдөд дэлгэрсэн Буддын шашин, Төвөдийн Буддын шашин (*Xizang Fojiao*) гэсэн нэр томъёог түлхүүтэй хэрэглэж байна. Ламын шашин (Lamaism) хэмээх нэр томъёоны талаар Lopez 1998: 15-45-д үзнэ үү.

“Буддын шашинт” БНХАУ нь Хятадын дуу хоолойг дэлхийн тавцанд хүргэх, Буддын шашныг дэмжигч улс орны дүр төрхийг бүрдүүлэх, холбоотон нетворк тогтоох зорилгоор 2006 оноос хойш Дэлхийн Буддын шашны Форум (*Shijie Fojiao Luntan World Buddhist Forum*) хэмээх олон улсын томоохон хурлыг тогтмол зохион байгуулж байна. Уг форум нь 2006 онд Ханжоуд, 2009 онд Үши-Тайбэйд, 2012 онд Хонгконгт, 2015 онд Үшид сүүлийн хурал нь 2018 онд Путянь хотод зохион байгуулагдсан.

Ханжоу хотноо хуралдсан Дэлхийн Буддын шашны анхны форум нь “Эв найртай даян дэлхий оюун санаанаас эхэлнэ” гэсэн хурлын уриатайгаар зохион байгуулагдсан бөгөөд тус форумд 34 орны 1,000 гаруй төлөөлөгчид оролцсон байна.¹ Тус хуралд анх удаа 17 настай XI Банчэн богд Жалцэн Норбу (*Gyaltzen Norbu*)² оролцсон бөгөөд тэрээр X Банчэн богдын “улс орноо нэгтгэх, улс орны нэгдэлд оруулсан их хувь нэмрийг” дурдан магтаж³ Хятадын буддистууд улс орноо хамгаалж ирсэн уламжлалаа үргэлжлүүлэхийг уриалжээ.⁴ Тус форумд XI Банчэн богдыг оролцуулснаар түүнийг Хятадын Төвөдийн Буддын шашны тэргүүлэх лам болохыг тус хуралд оролцсон дэлхийн буддистуудад харуулах анхны алхмыг хийсэн байна.

2018 онд хуралдсан V Дэлхийн Буддын шашны Форум нь “Бие биеэсээ суралцан солилцох нь: Төгс эв найрын төлөөх дундаж зам” нэртэйгээр зохион байгуулагджээ. Тус форум нь “Буддизм ба XXI зууны далайн торгон зам”, “Буддизм ба байгаль орчны хамгаалал” зэрэг долоон сэдвээр хуралдсан бөгөөд форумд 55 орны 1,000 төлөөлөгч оролцсон байна. Форумтай холбогдуулан Путянь хотын захирагч Ли Жяньхуй “Буддизм нь Хятадын уламжлалт соёл болон “Бүс ба зам” санаачилгыг дэлхийд түгээхэд эерэг үүргийг гүйцэтгэсээр ирсэн бөгөөд “Бүс ба зам”-ын төсөлд оролцож буй улс орнуудтай харилцахад гүүр болж байна.” хэмээн тэмдэглэжээ.⁵ Тус форумд Монгол Улсын зарим сүм хийдийн тэргүүнүүд

1 <http://www.china.org.cn/english/2006/Apr/165512.htm>

2 XI Банчэн богд Жалцэн Норбу нь 1990 онд төрсөн. 1995 оны намар 11 дүгээр сард Төвөдийн Лхас хотын Зуу хийдэд алтан хумхинаас шавга татан түүнийг тодруулсан байна. Ийнхүү тодруулахаас өмнө 1995 оны 5 сард Далай ламын тодруулсан хүүг гэр бүлийн хамт барьж авсан бөгөөд одоогоор Далай ламын тодруулсан хүү хаана байгаа талаар мэдээлэл байхгүй байна. 1996 онд НҮБ-ын шинжээчид Далай ламын тодруулсан Гэндүнчойжиням (*Gendun Choekyi Nyima*) хүүтэй уулзах хүсэлт тавих үед Женев хотноо БНХАУ-аас НҮБ-д суугаа байнгын төлөөлөгч Ү Жяньмин “эцэг эхийн нь хүсэлтийн дагуу [Хятад улсын] засгийн газар хамгаалтандаа авсан” хэмээн хариулсан байдаг. 2019 онд НҮБ-ын Хүчээр алга буюу сайн дураар бус алга бологсодын асуудлаарх ажлын хэсгийн 119 дүгээр ээлжит хурал дээр Гэндүнчойжиням хүүгийн талаар асуухад Хятадын тал Гэндүнчойжиням “үнэ төлбөргүй зайлшгүй суралцах боловсролоо” эзэмшээд “их сургуульд суралцсан” бөгөөд “одоо ажиллаж байгаа” хэмээн хариулсан байна. Гэндүнчойжиням хүү “засгийн газрын хамгаалтанд” орсоноос хойш 26 жил болж байна. Гэндүнчойжинямын талаар дэлгэрэнгүйг Hilton 2001; Klein 1999-д үзнэ үү.

3 1950 онд Хятадын АЧА Төвөдийн Кам муж руу довтлон орохоос өмнө ХКН нь X Банчэн богд болон Кам мужийн Бэри хийдийн хамба лам Гэдаг ринбүчийг өөрийн талд чадварлагаар ашиглаж чадсан байдаг.

4 http://english1.english.gov.cn/2006-04/13/content_253050.htm

5 <http://www.chinadaily.com.cn/a/201810/29/WS5bd65c3aa310eff3032850ee.html>

оролцсон бөгөөд хурлын үеэр XI Банчэн богдтой уулзалт хийсэн байна.

Дэлхийн Буддын шашны Форумтай адил хэмжээний олон улсын буддистуудын хурлыг БНЭУ нь Олон улсын Буддын шашны Чуулган (International Buddhist Conclave) нэртэйгээр 2004 оноос хойш зохион байгуулж байгаа бөгөөд 2018 онд VI Олон улсын Буддын шашны Чуулганыг Шинэ Дели хотод зохион байгуулсан. Тус чуулганд 29 орны төлөөлөгчид оролцсон бөгөөд чуулганыг БНЭУ-ын ерөнхийлөгч Рам Нат Ковинд (Ram Nath Kovind) нээн үг хэлсэн.¹

Мөн Японы Буддын шашны Ненбуцушу (Nenbutsushu) байгууллага нь 1998 оноос эхлэн Буддын шашны Чуулган (Buddhist Summit) зохион байгуулж буй бөгөөд 2017 онд Шри Ланкад VII Буддын шашны Чуулган хуралдсан. Тус чуулганд 47 улс орны төлөөлөгчид оролцсон байна.² 2014 оноос хойш Монголын Бурхан шашинтны төв, Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба лам Д.Чойжамц Буддын шашны Чуулганы ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

Монгол Улсын хувьд Улаанбаатар хотод байнгын удирдах төв нь байрлах Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурал (АБЭТБХ Asian Buddhist Conference for Peace) бол дэлхийн тавцанд Монгол Улсын нэр нөлөө, байр суурийг бэхжүүлэх, хамтын ажиллагаа, харилцаа холбоог амжилттай тогтоож байсан олон улсын Буддын шашны байгууллага юм. АБЭТБХ нь 1970 онд Улаанбаатар хотноо байгуулагдсан бөгөөд 1989 онд НҮБ-ын Эдийн засаг нийгмийн зөвлөлд зөвлөх статустай (UN ECOSOC roster consultative status) болсон. 1990 он гэхэд АБЭТБХ нь дэлхийн 12 оронд 15 үндэсний төвтэй, тус байгууллагын англи хэлээр хэвлэгдэн гардаг “Buddhists for Peace” хэмээх сэтгүүл нь 104 орны 530 шуудангийн хаягаар илгээгддэг олон улсын буддын шашны нэр хүнд, нөлөө бүхий байгууллага болсон байна. АБЭТБХ-ын XI Ерөнхий чуулган Улаанбаатар хотод хуралдсан.³

БНХАУ тус байгууллагын гишүүн улс биш бөгөөд 2003 онд БНАЛАУ-ын Вьентьян хотноо хуралдсан АБЭТБХ-ын X Ерөнхий Чуулганд Хятадын Буддын Холбооны (Buddhist Association of China *Zhongguo Fo jiao Xiehui*) дэд ерөнхийлөгч тэргүүтэй гурван төлөөлөгч анх удаа оролцсон. Тус чуулган дээр Хятадын тал АБЭТБХ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хүсэлтэй боловч Далай ламын Шашин, соёлын зөвлөл (the Council for Religious and Cultural Affairs) болон Тайваний Залуучуудын Буддын Холбоо (the Chinese Youth Buddhist Association of Taiwan) тус байгууллагын гишүүн байгаа нь саад болж байгаа бөгөөд Далай ламын Шашин, соёлын зөвлөлийн гишүүнчлэлийг цуцлах, Хятадын Тайбэй хэмээн нэрлэх хүсэлт тавьсан. 2019 онд Улаанбаатар хотод чуулсан АБЭТБХ-ын XI Ерөнхий чуулганд Хятадын төлөөлөгчид оролцоогүй.

1 <https://pib.gov.in/Pressreleaseshare.aspx?PRID=1543509>

2 <http://www.buddhist-summit.com/eng/summitkaisai/index.html>

3 АБЭТБХ-ын тухай дэлгэрэнгүйг Lkhagvademchig 2018: 81-105-д үзнэ үү. Төвч мэдээллийг <https://newspress.mn/v1/p/news/10789>-д харна уу.

**“Бүс ба зам” санаачилгын хүрээн дэх
“Буддын зам санаачилга”**

Ази, Номхон далайн бүс нутагт цэрэг, улс төр, эдийн засгийн нөлөөллөө тогтоох бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй “Бүс ба зам” санаачилгын хүрээнд Хятад улсын зүгээс Өмнөд болон Зүүн өмнөд Азийн буддист орнуудад нэгжгээд буддын төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Энэхүү өгүүлэлд Зүүн өмнөд Азийн буддист орнууд болох Мьянмар, Тайланд, Лаос болон Камбож улсад явуулж буй бодлого, төсөл хөтөлбөрийг¹ дурдалгүй БНЭУ-ын хөрш улсууд болох Шри Ланка, Пакистан, Бангладеш болон Непал улсуудад хэрэгжүүлж буй төслүүдийн талаар ярина.

Дээрх улсуудаас Шри Ланкаас бусад улс нь хэдийгээр Буддын шашинтай улс биш² боловч Хятад улс Буддын шашны төсөл хэрэгжүүлж байгаа нь нэгд, өмнө дурдсанчлан Буддын шашныг дэмжигч тэргүүлэгч улс орны дүр төрх бүрдүүлэх -энэ нь мөн Энэтхэг улсын Буддын шашны дипломат бодлоготой өрсөлдөх, хоёрт, Төвөдийн өндөрлөгийн бүс нутгийн аюулгүй байдлаа хангах, гуравт, Энэтхэгийн далайн бүс нутаг дахь эдийн засаг, цэрэг, улс төрийн нөлөөлөл, хүчээ бэхжүүлэх стратеги бодлогын хүрээнд Буддын шашны төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Энэтхэгийн далайн бүс нутагт БНХАУ-ын хэрэгжүүлж буй “Далайн торгон зам”-ыг судлаачид Хятадын эдийн засгийн тэлэлт, аюулгүй байдлыг хангах зорилготой “сувдан хэлхээ” (*strings of pearl*) стратегийн бодлого хэмээн нэрлэж байна.³ Шри Ланка, Пакистан, Бангладеш улсын Хамбантога, Гвадар, Читтагонг боомт нь “сувдан хэлхээний сувдууд” юм.⁴ Эдгээр “сувдан хэлхээ”-ний улсуудад Хятад улс дараах Буддын шашинтай холбоо бүхий төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Шри Ланка улсад 2019 онд Зүүн Өмнөд Азийн хамгийн өндөр цамхаг болох 350 метр өндөр “Лотус цамхаг” (Lotus Tower) нээлтээ хийсэн. Уг цамхгийн 104.3 сая ам.долларын санхүүжүүлэлтийг Хятадын ЕХИМ (Export and Import Bank of China) банк хийжээ.⁵ Тус цамхгийг “Лотус цамхаг” хэмээн нэрлэсэн нь бадам цэцэг нь Буддын шашинд цэвэр ариуны бэлгэдэл, мөн Хятадын Буддын шашинд нэн алдартай “Дээдийн ном цагаан бадам цэцэг” (*Saddharmapundarika-sutra*) хэмээх судрын нэрээр нэрлэсэн аж.

1 Тус улсуудад явуулж буй бодлого, төсөл хөтөлбөрийг Raymond 2020-д харна уу.

2 Непал улсын хүн амын 80.6% нь Хиндү шашинтай харин 10% нь Буддын шашинтай, Бангладеш улсын 90.8% муслим, 1% буддист харин Пакистан улсын 96.5% муслим, 1% буддист юм. <http://www.globalreligiousfutures.org/>

3 “Сувдан хэлхээ” стратеги бодлогын талаар Brewster 2016; Dixon 2014; Huang 2018; Krupakar 2017; Lim 2020-д харна уу.

4 БНХАУ 2015 оноос эхлэн Өмнөд Хятадын тэнгис, Энэтхэгийн далайн 8 далайн боомт тухайлбал Пакистаны Гвадар боомтыг 40 жил, Мьянмарын Куаукруу боомтыг 50 жил, Малайзын Кuantan боомтыг 60 жил, Шри Ланкын Хамбантога боомтыг 99 жилээр түрээсэлсэн. Бусад боомтын талаар Ghiasy 2018-д харна уу.

5 <https://china.aiddata.org/projects/33380>

Лотус цамхгийн талаар Шри Ланкын судлаач Патрик Мендис Лотус цамхаг нь “түүхэн Буддын шашинт улс үндэстэн болох Хятад, Шри Ланка хоёр улс нь Хиндү шашин давамгайлсан Энэтхэг, Христийн шашин зонхилох АНУ-аас ялгаатай болохыг харуулан Хятад, Шри Ланкын олон зууны шашин, соёлын харилцаа холбоог холбон өгч байна.” хэмээн өгүүлжээ.¹ Түүний хэлсэн үг нь чухамдаа Хятад улсын зүгээс явуулж буй Буддын шашны дипломат бодлогын нэгэн хүүрнэл буюу Хятад нь уламжлалт Буддын шашинт улс үндэстэн мөн, харин Энэтхэг нь хэдийгээр Буддын шашны өлгий нутаг мөн боловч Хиндү шашинт улс юм гэсэн утга санааг тод илэрхийлж байна.

Пакистан, Бангладеш улс нь Исламын шашин давамгайлсан улс боловч түүхийн хувьд Буддын шашин дэлгэрч байсан улс орнууд юм.² Хятад улс нь Пакистан, Бангладеш улсын зүгээс Буддын шашныг Азийн буддист орнуудтай харилцах нэгэн гүүр болгох, Буддын шашны түүхэн дурсгалт газруудаа сэргээн эргэл мөргөл, аялал жуулчлалын газар болгох бодлогыг дэмжин хамтран ажиллаж, тусламж дэмжлэг үзүүлж байна. Ийнхүү хамтын ажиллагаа, дэмжлэг үзүүлж буй нь Төвөдийн Буддын шашин дэлгэрсэн Бутан, Гималайн бүс нутаг, Непал дахь буддын шашны тэргүүн лам нар болон буддистууд Хятад улсыг талархах, дэмжих нөхцөл байдлыг үүсгэн нөлөөллөө тогтоох, Далай ламын нөлөөг бууруулах, мөн Энэтхэг улс нь Буддын шашны өлгий нутаг болохыг хүлээн зөвшөөрсөн ойлголтыг бууруулах зорилготой гэж хэлж болно.

Пакистаны Удаяана (Сват хөндий), Бангладешийн Викрампура (одоогийн Муншиганж дүүрэг) хэмээх газарт Төвөдийн Буддын шашны Нинма болон Гэлүг урсгалын үндсэн багш нар болох Бадмасамбхава (VIII зуун), Атиша (982-1054)³ нар мэндэлжээ. Хятад улс нь эдгээр газруудыг сэргээн засварлахад хамтран ажиллаж, тусламж дэмжлэг үзүүлж байна.

2017 онд Хятадын Шанши муж нь Пакистаны Кебар Пактунква (Khyber Pakhtunkhwa) мужтай⁴ Буддын шашны соёлын өвийн дурсгалт газруудыг хадгалан хамгаалах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.⁵ 2021 оны 10 сард Пакистаны Исламабад хотноо Торгоны замын төв (Silkroad Centre) хэмээх байгууллага Пакистаны Кайд-и-Азам Их сургууль (Quaid-i-Azam University),

1 <https://jia.sipa.columbia.edu/online-articles/china%E2%80%99s-buddhist-diplomacy-why-do-america-and-india-entangle-tiny-sri-lanka> Мөн Mendis 2017-г харна уу.

2 Пакистан, Бангладеш дахь Буддын шашны түүхийн талаар Brancaccio and Kurt Behrendt 2006; Chaudhuri 1987; Niyogi 2016; Pakistani Buddhist 1963-д харна уу.

3 Бадмасамбхава (Монголд Ловон Бадамжунай хэмээн мөн нэрлэдэг) тухай Tsogyal 1999; Zangpo 2002-д харна уу. Атиша гэгээн (Жовужэ Балдан Атиша хэмээн мөн нэрлэдэг) нь 1042-1054 он хүртэл 12 жил Төвөдөд Буддын шашны сургаал ном номножээ. Түүний туурвисан “Бодь мөрийн зул” (*Bodhipathapradipa*) хэмээх зохиол дээр тулгуурлан Богд Зонхова (1357-1419) “Бодь мөрийн зэрэг” (*byan chub lam rim*) хэмээх алдарт зохиолоо туурвисан. Атиша гэгээний төвөд шавь нар болох Бромдон Жалвийжунай (Dromton Gyelwa Jungne 1004-1064), Ог Лэгвийшийрав (Ngok Lekpai Sherab 1059-1109) нар Төвөдийн Гадамбын ёсыг үндэслэсэн бөгөөд улмаар уг ёсноос Гэлүг урсгал үндэслэжээ. Атиша гэгээний талаар Chattopadhyaya 1981 [1967]; Das 1965 [1893]-д харна уу.

4 Кебар Пактунква мужид Удаяана зэрэг Буддын шашны дурсгалт газрууд байдаг.

5 <https://www.dawn.com/news/1314715>

Такшилын Азийн соёл иргэншлийн институттэй (Taxila Institute of Asian Civilizations) хамтран “Пакистан дахь Буддын шашин” сэдэвт олон улсын хурлыг зохион байгуулах гэж байна.

Тус олон улсын хуралд зориулан хийсэн цахим хуудсанд “Пакистан бол дэлхийн сая сая буддистуудын нэгэн ариун мөргөлийн орон юм. Тус орон нь Их Хөлгөний Буддын шашны өлгий нутаг бөгөөд Гүрү Ринбүчэ (Бадмасамбхава хэмээн мөн нэрлэгддэг) болон Марананта мэндэлсэн нутаг юм. Төвөд, Непал, Бутаны буддын шашинтнуудын хувьд Бадмасамбхава нь “хоёрдогч Бурхан Буддха” юм. Марананта¹ Чота Лахоре (Chhota Lahore)-с Хятадын нутгаар дамнан Солонгост очиж Буддизмын сургаал ном заасан юм.” хэмээн бичжээ.²

Энэ цахим хуудасны бичвэр нь Пакистан нь Буддын шашны Их Хөлгөний³ өлгий нутаг юм гэсэн бодлогын мессежийг тодорхой илэрхийлж байна. Сүүлийн жилүүдэд Бутан, Өмнөд Солонгос, Тайланд, Шри Ланка улсын Буддын шашны тэргүүн лам хуврагууд Пакистанд айлчлах болсон нь тус бодлого тусгалаа олж буйг харуулж байна.⁴

Дээр дурдсан Төвөдийн Буддын шашны Гэлүг урсгалын багш Атиша гэгээний мэндэлсэн Викрампура хэмээх газарт Хятадын Хунань мужийн Археологийн хүрээлэн 2014 оноос хойш Бангладешийн Жахангирнагар Их сургуультай (Jahangirnagar University) хамтран археологийн малтлага хийж байгаа бөгөөд малтлагын үр дүнд 1,000 жилийн өмнөх Буддын шашны сүм хийд, суварга бүхий хот газрыг илрүүлсэн байна.⁵ Тус газар 2017 онд Хятадын тусламжаар Атиша гэгээний дурсгалын суварга цогцолборыг барьсан⁶ бөгөөд нээлтийн үйл ажиллагаанд Хятадын Буддын Холбооны дэд ерөнхийлөгч Чюнь И, БНХАУ-аас

1 Марананта (Marananta мөн Malananda хэмээн бичдэг) нь 384 онд Солонгосын Пэгжэ (Paekche) улсад ирэн 385 онд Пэгжэ улсын нийслэлд Буддын сүм байгуулан 10 залууд сахил өгөн хувраг болгосон байна.

2 <https://buddhisminpakistan.org/>

3 Их Хөлгөний Буддын шашинтай улс орнуудад Хятад, Солонгос, Япон, Вьетнам улс орно. Монгол, Төвөд болон Бутан улсад Их Хөлгөний доторх Очирт хөлгөний ёс дэлгэрсэн. Очирт хөлгөний ёсыг таршийн ёс хэмээн мөн нэрлэдэг.

4 2012 онд Бутаны Шашны төв байгууллагын ловон Гүнсанванди (Lopon Kunzang Wangdi) (<http://mofa.gov.pk/meeting-of-buddhist-delegation-with-minister-of-state/>), 2019 оны 10 дугаар сард Дэлхийн Буддын Холбооны (World Fellowship of Buddhists) дэд ерөнхийлөгч Тайландын хамба лам Араяавонгсо (Arayawongso) (<https://www.buddhistdoor.net/news/thai-buddhist-delegation-visits-heritage-sites-in-pakistan>), 2019 оны 11 дүгээр сард Өмнөд Солонгосын Чоге урсгалын тэргүүн Воньхэн (Wonhaeng) нар Пакистан улсад айлчилсан. Пакистаны Шашны хэрэг эрхлэх яамны сайд хамба лам Араяавонгсотой уулзах үеэр Пакистаны засгийн газар Пешавар эсвэл Сват-д Буддын шашны Их сургууль байгуулах талаар төлөвлөж байгаа хэмээн хэлжээ. Чоге урсгалын тэргүүн Воньхэнийг Пакистаны Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Шашны хэрэг эрхлэх яамны сайд болон ГХЯ-ны сайд хүлээн авч уулзсан байна (<http://mofa.gov.pk/call-on-by-the-most-venerable-wonhaeng-president-of-jogye-order-of-the-republic-of-korea-on-the-foreign-minister-of-pakistan/>).

5 Бангладеш улсад хийсэн археологийн малтлаг нь Хятад улс Энэтхэгийн хойгт хийсэн анхны археологийн малтлаг юм. (<https://www.globaltimes.cn/content/1085085.shtml>).

6 Суварга цогцолбор барихад Хятадын Буддын Холбооны дэд ерөнхийлөгч Төвөд хувилгаан лам Түвдэнхайдүв (Thubten Khedrup) 1 сая юань буюу 150,000 ам.доллар хандивласан байна. http://www.china.org.cn/china/2016-07/31/content_38992177.htm

Бангладеш улсад сууж буй элчин сайд Ма Минчянь нар хүндэт зочноор оролцжээ. Хятад улс нь Атиша гэгээнийг Хятад, Бангладешийн олон зуун жилийн соёлын харилцааны бэлгэ тэмдэг хэмээн үзэж байна.¹

2019 оны 10 дугаар сард БНХАУ-ын дарга Ши Жиньпин Непал улсад айлчлахаас өмнө түүний нийтлэл Непалын гурван сонинд хэвлэгдсэн бөгөөд тус нийтлэлдээ тэрээр “Лүмбини дэх Хятадын Жунхуа буддын хийд нь бидний шашин, соёлын харилцааны бас нэгэн бэлгэ тэмдэг юм.”² хэмээн тэмдэглэжээ. Тус буддын хийдийг Хятадын Буддын Холбоо 2000 онд барьж ашиглалтад оруулсан бөгөөд Хятадын Буддын Холбооны гадаадад барьсан анхны буддын сүм хийд юм.³

Непалын Лүмбини хэмээх газар Хятадын буддын хийдийг онцгойлон барихын ач холбогдол юу вэ? Буддын шашны үүднээс харах юм бол ийм асуулт тавих шаардлага үгүй юм. Учир нь Лүмбини бол буддын шашинтнуудын эргэл мөргөлийн дөрвөн их ариун газрын нэг юм.⁴ Лүмбинийн цэцэрлэгт Бурхан Буддха мэндэлжээ.⁵

Харин газар зүйн байрлалын хувьд авч үзэх юм бол Лүмбини нь Энэтхэгийн хилээс 30 гаруй км-ийн зайтай газар юм. 2011 оноос хойш “Лүмбини төсөл” буюу Лүмбинийг хөгжүүлэн “Буддын Мекка” болгох 3 тэрбум ам.долларын төсөв бүхий төсөл яригдаж байгаа⁶ бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхээр анхлан яригдсан байгууллага нь Ази, Номхон далайн харилцаа хамтын ажиллагааны сан (Asia Pacific Exchange and Cooperation Foundation *Yatai Jiaoliu yu Hezuo Jijin Hui*) юм.⁷ Тус байгууллагыг Хятадын засгийн газартай холбоотой гэж үздэг.

Лүмбинийг буддистуудын эргэл мөргөлийн Мекка болгох уг төслийн хамтад Төвөдийн Лхас хотыг Непалын Катманду хоттой төмөр замаар холбох улмаар Лүмбини хүртэл төмөр зам тавих тухай гэрээ хэлэлцээр, ТЭЗҮ хийгдэж төмөр замын ажил эхлээд явж байна.⁸ Хэрэв Лүмбини хүртэл төмөр зам тавигдах юм бол

1 Бангладеш улсын хувьд 2004 онд Атиша Дипанкарын нэрэмжит Атиша Дипанкар Шинжлэх ухаан, Технологийн Их сургууль (Atish Dipankar University of Science and Technology) байгуулсан.

2 <https://www.chinadaily.com.cn/a/201910/11/WS5da026bba310cf3e3556ff60.html>

3 <https://www.fmprc.gov.cn/ce/cenp/eng/Culture/wh/t839483.htm>

4 Бусад гурван их мөргөлийн газар нь Энэтхэгт байдаг. Үүнд Бурхан Буддха гэгээрсэн Бодьгаяа, номын хүрд эргүүлсэн Сарнат болон нирваан дүр үзүүлсэн Кушинагар хот юм.

5 Одоогийн Непалын нутаг дэвсгэрт орших Лүмбини цэцэрлэгт Бурхан Буддха мэндэлсэн тул непалчууд Бурхан Буддхаг непал хүн хэмээн үздэг бөгөөд 2020 онд Энэтхэгийн ГХЯ-ны сайд С.Жаяшанкар (S.Jaishankar) Энэтхэгийн зөөлөн хүчний бодлогын талаар ярих үедээ Бурхан Буддха бол “Энэтхэгийн аугаа их хүмүүн” гэж хэлсэнийг Непалын ГХЯ няцаан мэдэгдэл гаргасан. <https://www.thehindu.com/news/national/nepal-india-in-war-of-words-over-buddhas-origins/article32310760.ece> 2017 онд Далай лам яриан завсраа Бурхан Буддхаг энэтхэг хүн гэж хэлсэнд непалчууд эсэргүүцэл илэрхийлсний дагуу Далай ламын ажлын алба залруулга хийсэн байдаг. <https://www.dalailama.com/news/2017/clarification-of-an-answer-to-a-students-question-in-meerut-india>

6 <https://www.aljazeera.com/features/2011/7/17/the-lumbini-project-chinas-3bn-for-buddhism>

7 Тус байгууллагын Лүмбини төслийн талаар http://www.apecf.org/en/work_projects/lumbini/index.html -д үзнэ үү.

8 <https://mofa.gov.np/joint-statement-between-nepal-and-the-peoples-republic-of-china-2/>; <https://mofa.gov.np/list-of-instruments-singed-and-exchanged-between-nepal-and-china/>; <https://www.railway-technology.com/news/china-to-commence-work-for-rail-link-to-nepal/>

Хятад Энэтхэгийн хилд 30 км дөхөж очих юм.¹

Энэ байдлаас сэргийлж Энэтхэг Непалын засгийн газартай гэрээ хэлэлцээр хийн Энэтхэгийн Раксаул (Raxaul) хотоос Катманду хүртэл өргөн царигтай² төмөр зам тавихаар яриа хэлэлцээ хийн, урьдчилсан ТЭЗҮ-г гүйцэтгэсэн байна.³

Дашрамд дурдахад 2001 онд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди Непал улсад төрийн айлчлал хийх үеэр талууд Лүмбинид Монгол буддын сүм барих талаар тохиролцсон бөгөөд 2016 онд ГХЯ-ны сайд Ц.Мөнх-Оргил Непал улсад айлчлал хийх үеэр дахин баталгаажуулсан байна.⁴

Дүгнэлт

БНХАУ-ын зүгээс явуулж буй соёлын зөөлөн хүчний бодлого тэр дундаа Буддын шашнаар дамжуулан явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь нэг талдаа бусдын сэтгэлийг өөртөө татах, нөлөөлөх, Хятад улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөх зорилго агуулж буй бөгөөд нөгөө талдаа тус улсын цэрэг, эдийн засаг, улс төр, аюулгүй байдлын стратеги зорилт, зорилгодоо хүрэх нэгэн зам гүүр нь болж байна.

БНХАУ-ын Буддын шашны зөөлөн хүчний бодлого, үйл ажиллагааг дараах гурван үндсэн чиглэлд явагдаж байна хэмээн дүгнэж болно. Нэгд, Хятад улс нь Буддын шашныг дэмжигч тэргүүлэгч орон гэсэн дүр төрхийг бүрдүүлэх, хоёрт, “Бүс ба зам” санаачилгын нэгэн адил Хятадын ашиг сонирхол, нөлөөллийг тогтоох “Буддын зам” санаачилга хэрэгжүүлэх, гуравт, Төвөдийн өндөрлөгийн бүс нутгийн аюулгүй байдлаа хангах хүрээнд Гималайн бүс нутагт Хятад улсын нөлөөллийг тогтоох, Далай ламын нэр хүнд, нөлөөг бууруулах зорилготой үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна.

1 Транс Гималайн төмөр замын талаар Pokhrel 2021:36-39-д үзнэ үү.

2 Хятадын талаас Непалын Катманду хүртэл тавих төмөр зам нь нарийн царигтай байх юм.

3 http://www.mea.gov.in/Uploads/PublicationDocs/32489_AR_Spread_2020_new.pdf; <https://www.mea.gov.in/press-releases.htm?dtl/33391/Sixth+IndiaNepal+Joint+Commission+Meeting>

4 <https://kathmandupost.com/miscellaneous/2016/12/20/nepal-mongolia-sign-a-host-of-agreements>

Лавлагаа ном зүй

- Angelskar, Trine. 2013. *China's Buddhist Diplomacy*. NOREF Report.
- Brancaccio, Pia and Kurt Behrendt. 2006. *Gandharan Buddhism: Archaeology, Art and Texts*. Vancouver: University of British Columbia.
- Breslin, Shaun. 2020. China's Global Cultural Interactions. In *China and the World*. David Shambaugh, ed. Pp.137-155. Oxford: Oxford University Press.
- Brewster, D. 2016. Silk Roads and strings of pearls: The strategic geography of China's new pathways in the Indian Ocean. *Geopolitics* 22(2): 271–72.
- Casanova, Jose. 1994. *Public Religion in the Modern World*. Chicago: Chicago University Press.
- Chattopadhyaya, Alaka. 1981 [1967]. *Atiśa and Tibet*. Delhi: Motilal Banarsidas.
- Chaudhuri, Sukomal. 1987. *Contemporary Buddhism in Bangladesh*. Calcutta: Atisha Memorial Publication Society.
- Das, Sarat Chandra. 1965 [1893]. *Indian Pandits in the Land of Snow*. Calcutta: Firma K.L. Mukhopadhyay.
- Dixon, Jonathan. 2014. From “Pearls” to “Arrows”: Rethinking the “String of Pearls” Theory of China's Naval Ambitions. *Comparative Strategy* 33(4): 389-400.
- Fox, Jonathan., and Shmuel Sandler, eds. 2004. *Bringing Religion back into International Relations*. New York: Palgrave.
- Ганбат., Би Аонань, ред. 2014. *Монгол-Хятад хоёр улсын түүхэн харилцааны он дараалсан лавлах (1949-2014)*. Улаанбаатар: Арвай бархан.
- Ghiasu, Richard, Fei Su and Lora Saalman. 2018. *The 21st Century Maritime Silk Road: Security implications and ways forward for the European Union*. Stockholm International Peace Research Institute.
- Гомбожав. 2016 [1746]. *Хятад орноо Бурхны шаашин дэлгэрсэн түүх*. Тэрбишийн Чулуун-Эрдэнэ, орч. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Green, John C. 2007. *The Faith Factor: How Religion Influences American Elections*. Westport: Praeger.
- Haicheng, Ling. 2005. *Buddhism in China*. Beijing: China Intercontinental Press.
- Haynes, Jeffrey, ed. 2009. *Routledge Handbook of Religion and Politics*. London: Routledge. 2016. *Religious Transnational Actors and Soft Power*. London: Routledge.
- Hilton, Isabel. 2001. *The Search for the Panchen Lama*. New York: W.W. Norton.

- Huang, Mike Chia-Yu. 2018. A New Game Started? China's 'Overseas Strategic Pivots' in the Indian Ocean Region. *China Report* 54 (3): 267-284.
- Жиньпин, Ши. 2019. *Төр улсыг засах тухай I*. Бээжин: Гадаад хэлний хэвлэлийн газар.
- Klein, Richard. 1999. The World's Youngest Political Prisoner. *Humanist* March/April 1999: 9-14.
- Klimes, Ondrej. 2017. China's Cultural Soft Power: The Central Concept in the Early Xi Jinping Era (2012-2017). *AUC Philologica* 2017(4): 127-150.
- Korkut, Senol. 2010. The Diyanet of Turkey and Its Activities in Eurasia after the Cold War. *Acta Slavica Iaponica* 28:117-139.
- Krupakar, Jayanna. 2017. China's Naval Base(s) in the Indian Ocean—Signs of a Maritime Grand Strategy? *Strategic Analysis* 41(3): 207–222
- Kurlantzick, Joshua. 2007. *Charm Offensive: How China's Soft Power is Transforming the World*. New Haven: Yale University Press.
- Lai, Hongyi and Yiyi Lu. 2012. *China's Soft Power and International Relations*. London: Routledge.
- Li, Mingjiang. 2009. *Soft Power: China's Emerging Strategy in International Politics*. Lanham: Lexington Books.
- Lim, Yves-Heng. 2020. China's rising naval ambitions in the Indian Ocean: aligning ends, ways and means. *Asian Security* 16(3): 396-412.
- Litian, Fang. 2014. On the Sinicized Marxist View of Religion. In *Marxism and Religion*. Lu Daji and Gong Xuezheng, eds. Pp. 321-347. Leiden: Brill.
- Lkhagvademchig, Jadamba. 2018. *Double Headed Mongolian Buddhism: A Historical and Anthropological Study on Identity Politics inside the Mongolian Buddhist Institution*. PhD dissertation. University of Shiga Prefecture.
- Lord, Ceren. 2018. *Religious Politics in Turkey: From the Birth of the Republic to the AKP*. Cambridge: Cambridge University Press.
- Lopez, Donald S. 1998. *Prisoners of Shangri-La: Tibetan Buddhism and the West*. Chicago: University of Chicago Press.
- Mendis, Patrick. 2017. Can past be prologue in Sino-Sri Lankan discourse? The Colombo Lotus Tower as a 'Buddhist Way' to navigate geopolitical rivalry between China and India? *Harvard International Review* 38 (4): 34-38.
- Modi, Renu. 2016. Indian and Chinese Soft Power in Africa. In *China-Africa Relations in an Era of Great Transformations*. Li Xing and Abdulkadir Osman Farah, eds. Pp.127-143. London: Routledge.

- Moyser, George. 1991. *Politics and Religion in the Modern World*. London: Routledge.
- Niyogi, Puspa. 2016. *Buddhism in Ancient Bengal*. Kolkatta: Maha Bodhi Book Agency.
- Norris, Pippa and Ronald Inglehart. 2004. *Sacred and Secular: Religion and Politics Worldwide*. Cambridge: Cambridge University Press.
- Nye, Joseph. 1990. Soft Power. *Foreign Policy* 80: 153-71. 2005. *Soft Power: The Means to Success in World Politics*. New York: Public Affairs Books.
- Pakistani Buddhist. 1963. *Buddhism in Pakistan*. Karachi: Pakistan Publications.
- Palit, Param Sinha. 2017. *Analysing China's Soft Power Strategy and Comparative Indian Initiatives*. New Delhi: Sage Publications.
- Peterson, Rachele. 2017. *Outsourced to China: Confucius Institutes and Soft Power in American Higher Education*. National Association of Scholars.
- Pokhrel, Kabi Prasad. 2021. Nepal-China-India Relation: A Geostrategic Perspectives. *APF Command and Staff College* 4(1): 28-40.
- Raymond, Gregory V. 2020. Religion as a Tool of Influence: Buddhism and China's Belt and Road Initiative in Mainland Southeast Asia. *Contemporary Southeast Asia* 42 (3): 346-371.
- Shambaugh, David. 2013. *China goes global: the Partial Power*. Oxford: Oxford University Press.
- Thomas, M. Scott. 2005. *The Global Resurgence of Religion and the Transformation of International Relations*, New York: Palgrave.
- Tsogyal, Yeshe. 1999. *The Lotus-Born: The Life Story of Padmasambhava*. Translated by Erik Pema Kunsang. Boston: Shambala Publications.
- Xiaowen, Ye. 2000. Dangqian woguo de zongjiao wenti-Guanyu zongjiao wuxing de zai tantao. In *Zhongguo zongjiao yanjiu nianjian: 1997-1998*. Cao Zhongjian, ed. Pp.1-27. Beijing: Zongjiao wenhua chubanshe.
- Wang, Jian, ed. 2011. *Soft Power in China: Public Diplomacy through Communication*. New York: Palgrave Macmillan.
- Zangpo, Ngawang. 2002. *Guru Rinpoche: His Life and Times*. Ithaca, NY: Snow Lion Publications.
- Zhang, Xioling, Herman Wasserman, and Winston Mano, eds. 2016. *China's Media and Soft Power in Africa: Promotions and Perceptions*. New York: Palgrave Macmillan.
- Zürcher, E. 2007 [1959]. *The Buddhist Conquest of China: The Spread and Adaptation of Buddhism in Early Medieval China*. 3rd edn. Leiden: Brill.